



ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Бүтцийн зохион байгуулалт
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” 352 дугаар тогтоол, 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчилэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, 2019 оны 07 дугаар сарын 3-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 276 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/144 тоот тушаалаар батлагдсан “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.7, Эмнэлгийн захирлын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/50 тоот тушаалаар батлагдсан “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын 4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Амаржих газрын эмч, эмнэлгийн ажилтнуудын орон тоо, албан тушаалын зэрэглэлийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах алба, тасаг, ажилтнуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар, бүтцийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн мөрдөн ажилласугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /П.Эрдэнэцэцэг/, Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал /О.Баянжаргал/, Санхүүгийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч /У.Мөнхболор/ нарт даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захиралын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Бүтцийн зохион байгуулалт хийх тухай” А/21 тоот тушаал, нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Ж.ЭНХЦЭЦЭГ

D:\Тушаал 2022\А тушаал

Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн захирлын 2022 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн тоот тушаалын гуравдугаар хавсралт



"ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР" ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН БҮТЭЦ

